



Г.ТУВААНЫ НЭРЭМЖИТ
НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД
ХАМТДАА АЯН - 2023

АВЛИЦЫН ЭСРЭЛ

...**НЭГДЭЭ**

 110

“ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА” АЯНЫ ХҮРЭЭНД

Г.ТУВААНЫ НЭРЭМЖИТ НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН

ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2023.07.24

Сайнцагаан сум



Дундговь аймгийн Г.Тувааны нэрэмжит Нэгдсэн эмнэлэг нь “Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа” аянд 2023 оны 07 сарын 05-ны өдрөөс 07 сарын 12-ны өдрүүдэд нэгдэж иргэд үйлчлүүлэгч, олон нийт болон байгууллагын ажилчдад авлигын нийгэм, эдийн засгийн хор хөнөөлийг таниулах, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэх үйл ажиллагааг зохион байгууллаа.

“Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа” аяны хүрээнд:


- Нэгдсэн эмнэлгийн албаны дарга, тасгийн эрхлэгч, аргазүйч нарт Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа аян зохион байгуулах тухай танилцуулж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч АВЛИГАГҮЙ НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА-НЭГДЬЕ уриатайгаар нэгдсэн эмнэлгийн хамт олон нэгдлээ.



- Байгууллагын албан ёсны FB пэйж хаягийн cover зургийг шинэчлэн авлигын эсрэг нэгдье уриатай олон нийтийн сүлжээнд нийтэллээ. Мөн АТГ-с нийтэлсэн сурталчилгааны видео постеруудыг цаг тухай бүрт нь байгууллагын цахим хаягаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.



- Авлигатай нийгмийг өөрчлөхийн тулд, ашиг сонирхлын зөрчлийг таслан зогсоохын тулд, ил тод байдлыг хангахын тулд, хариуцлага, ёс зүйг сайжруулахын тулд авлигагүй нийгмийн төлөө хамтдаа уриатай өөрсдийн бэлтгэсэн видео, шторк бэлдэж байгууллагын FB пэйж хуудсанд байршуулан хамт олон болон олон нийтийг уриалж ажиллалаа.



- Нэгдсэн эмнэлгийн алба, тасаг нэгжүүдийн мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг үйлчлүүлэгч нарт сурталчилан АТГ-ын санал гомдол хүлээн авах 110 дугаарын талаар мэдээлэл байршуулж Авлигын эсрэг нэгдэхийг уриаллаа.



- Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт Авлига албан тушаалын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэхийг уриалсан видео бичлэгийг TV дэлгэцээр иргэд үйлчлүүлэгч нарт хүргэж ажиллалаа.



ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН: НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.ЭНХЗОРИГТ

ТАЙЛАН БИЧСЭН: МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТАН

О.МӨНГӨНХУНДАГА